

## **Нүүдэлчин ард ба байгаль хамгаалахад чиглэсэн Тунхаглал**

*2002 оны 4-р сарын 3-7 ны өдрүүдэд нийгмийн болон байгаль орчны чиглэлээр мэргэжсэн олон улсын эрдэмтэн, мэргэжилтэнүүд нүүдэлчин ард түмний эрх ашиг, байгаль хамгаалах асуудалд чиглэсэн цогц арга замыг боловсруулахаар дэлхийн янз бүрийн орнуудаас Иорданы Вади Дана Байгалийн Нөөц Газарт цугласан юм.*

Дэлхийн биологи төрөл зүйлийг хамгаалах, зүй зохистой хэрэглэх асуудалд урьд өмнө байгаагүйгээр аюул заналхийлэх боллоо. Үүний зэрэгцээ, дахин давтагдашгүй, хэмжээлшгүй их мэдлэг, чадварыг агуулагч хэл, соёлын олон төрөл хэлбэр түгшүүртэйгээр хурдан устаж байна.

Хүн амын эрс өсөлт, зүй зохисгүй хэрэглээ, цаг уурын өөрчлөлт, үндэсний болон дэлхийн эдийн засгийн хүчнүүдийн харилцан уялдаатай дарамт шахалтууд нь биологийн нөөц баялаг, нутгийн уугуул ардын амьжиргаанд заналхийлж байна. Ялангуяа, нүүдэлчин ардууд хирээс хэтэрсэн хүчнүүдийн дарамт шахалтад орж хүчин мөхөсдсөөр.

Нүүдэлчин ардыг ялгаварлан гадуурхаж, тэдний эрхийг, тэр дундаа байгалийн нөөц баялагийг ашиглах эрхийг үгүйсгэж байгаль хамгаалах үйл хэрэгт нүүдэлчдийн зовнилийг хангалттай хэмжээгээр тусгаж чадахгүй байна. Эдгээр хүчин зүйлүүдээс мөн дэлхийн өөрчлөлтөөс болж нүүдэлчин ардын амьдралын хэв маягт сөрөг нөлөө гарч, байгалийн тэнцвэрт байдлыг хангаж амьдрах чадвар нь буурч, бусдаас ялгагдах байдалд нь аюул учирах боллоо.

Хэдийгээр нүүдэлчин ардын хувь нэмэр тэр болгон үнэлэгддэггүй ч гэлээ, байгалийн нөөц баялагийг ашиглах уламжлалт арга барил, байгалиа хүндэтгэх ёс заншлынхаа дагуу тэд дэлхийн экосистем, биологи төрөл зүйлүүдийг нөхөн сэргээхэд хувь нэмэр оруулсаар байна. Нүүдэлчин ардын ашиг сонирхол байгаль хамгаалах ашиг сонирхолтой нийцдэг тул байгаль хамгаалах асуудлаар ажиллаж буй хүмүүс, нүүдэлчин ардын хооронд харилцан холбоо бүхий нөхөрлөлийг байгуулах нэн шаардлагатай байна.

Энэхүү ойлголтын үүднээс бид дараах зарчмуудад тулгуурлан байгаль хамгаалах ажлыг сайжруулахад баттай зогсож байна. Үүнд:

### **1-Р ЗАРЧИМ. ЭРХ, ЭРХ МЭДЭЛ**

Нүүдэлчин ард, тэдний байгалийн нөөц баялагт нөлөө үзүүлж болохуйц байгаль хамгаалах арга хандлагуудыг боловсруулахдаа нүүдэлчин ардын эрх, менежментийн хариуцлага, чадварыг үнэлж тэдэнд үр дүнтэй эрх мэдэл өгөхөд чиглүүлэх хэрэгтэй. Эрх гэдэгт,

- 1.1 Хүний эрх: иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засгийн, соёлын
- 1.2 Газар, байгалийн нөөцийн эрх, хуулиар олгогдсон эрх
- 1.3 Соёлын болон оюуны өмчийн эрх
- 1.4 Янз бүрийн төвшинд хэлэлцээр хийх, шийдвэр гаргахад оролцох эрх
- 1.5 Орон нутгийн байгалийн нөөц баялагийг ашигласанаас хүртэх хувийг тэгш эрхтэйгээр хуваалцах эрх

Эцэст нь зохих хууль зүйн шинэчлэлийг үндэсний болон олон улсын төвшинд шаардлагатай хэмжээнд хүртэл хийх хэрэгтэй. Мөн нүүдэлчин ард нутаг дэвсгэр дамжин нүүдэлдэг учир улс үндэстэнүүдийн хооронд хил дамжсан хамтын ажиллагаа байх шаардлагатай юм.

Нүүдэлчин ардын эрхийг хүлээн зөвшөөрсөнөөр тэдний нас, хүйсийг харгалзан эрх мэдлийг үр ашигтайгаар шилжүүлэх нь чухал юм.

## **2-Р ЗАРЧИМ. ИТГЭЛЦЭЛ, ХҮНДЛЭЛ**

Нүүдэлчин ард, байгаль хамгаалах ашиг сонирхол бүхий талуудын хамтарсан холбоо нь харилцан итгэлцэлд тулгуурлах бөгөөд нүүдэлчин ардыг ялгаварлан гадуурхах асуудлыг цохон тэмдэглэж хүндэтгэн үзэх хэрэгтэй.

- 2.1 Тэгш эрхтэй байх
- 2.2 Нүүдэлчин ардын байгууллагыг бүрэн хүндэтгэн үзэж хүлээн зөвшөөрөх
- 2.3 Бүх талуудын эрх, үүргийг тэнцвэржүүлэх
- 2.4 Холбогдох хуулийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нийцүүлэх
- 2.5 Байгаль хамгаалах зорилгоо биелүүлэх, нүүдэлчин ардын хэрэгцээг хүндэтгэхэд бүх талуудын хариуцлагыг өндөржүүлэх

## **3-Р ЗАРЧИМ. МЭДЛЭГИЙН ЯЛГАВАРТАЙ СИСТЕМ**

Биологи төрөл зүйлийг хамгаалах ажлыг нүүдэлчин ардын оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлэхдээ тэдний мэдлэг, менежментийн арга барилыг хүндэтгэн түүнд нь нийцүүлж байх нь зүйтэй. Төгс мэдлэг гэж байдаггүй тул уламжлалт болон орчин үеийн шинжлэх ухааныг хослуулах нь нүүдэлчин ардын өөрчлөгдөж буй хэрэгцээг хангаж байгаль хамгаалах асуудалд хариу өгөх давуу талтай юм. Ялангуяа:

- 3.1 Уламжлалт болон орчин үеийн шинжлэх ухаан, менежментийн хосолсон арга барил нь харилцан тэгш эрх бүхий хэлцэл дээр үндэслэх бөгөөд аль алианаас нь сурч болдог.
- 3.2 Уламжлалт болон орчин үеийн шинжлэх ухааныг аль алиныг зохих ёсоор үнэлэх бөгөөд тэдгээрийн мөн чанарыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

## **4-Р ЗАРЧИМ. ДАСАН ЗОХИЦОХ МЕНЕЖМЕНТ**

Нүүдэлчин ардын амьдарч, ашиглаж ирсэн нутаг дэвсгэрт биологи төрөл зүйл, байгалийн нөөц баялагийг хамгаалахдаа дасан зохицох менежментийн арга хандлагуудыг хэрэглэх шаардлагатай юм. Иймэрхүү арга хандлагууд нь уламжлалт болон орчин үеийн соёл, шинжлэх ухааны загварт үндэслэж, нүүдэлчин ардын ертөнцийг үзэх үзэл, хүсэл эрмэлзэл, хуульд нийцсэн байх хэрэгтэй. Эдгээр арга хандлагууд нь мөн нүүдэлчин ардын аж төрөл, соёлыг хэвээр нь авч үлдэх, биологи төрөл зүйлийг урт хугацаанд хамгаалахад чиглэсэн байвал зүйтэй.

Энэхүү дасан зохицох менежментийн арга хандлагыг нэн ялангуяа нүүдэлчин ардын амьдралын хэв маяг, нөөц баялагийн тогтвортой менежментийн байгаль хамгаалах зорилго бүхий ашиг сонирхолтой үед бий болгох хэрэгтэй.

- 4.1 Амьжиргааны өөр эх үүсвэрүүдийг бий болгох, бүх төвшинд янз бүрийн хэлбэрээр хувь хүртэж байх,
- 4.2 Нөөц баялагийг ашиглах боломж эрх, тэр дундаа нөөц баялагийг хуваалцах эрхийн олон төрөл системийг хүлээн зөвшөөрөх
- 4.3 Гаршуулсан мал, ургамалын төрөл зүйлийг сайжруулан хамгаалахад оруулж буй нүүдэлчин ардын хувь нэмрийг үнэлэн дэмжих
- 4.4 Байгаль хамгаалах ажлыг үр дүнтэй болгож буй нүүдэлчин ардын уян хатан менежментийн арга барилаас суралцах
- 4.5 Байгаль хамгаалах төлөвлөгөөг гаргахдаа том хэмжээний нутаг дэвсгэрийг хамруулах хэрэгтэй бөгөөд ингэхдээ нүүдэл, шилжилтийг гол концепциэ болгон экологи, соёлын талын аль алийг нь хослуулах

## 5-Р ЗАРЧИМ. ХАМТЫН МЕНЕЖМЕНТ

Дасан зохицох менежментэд тохирсон байгууллагын бүтэц нь нүүдэлчин ард, байгаль хамгаалах агентлагуудын харилцан тэгш эрх бүхий шийдвэр, менежментийн үүрэг хариуцлагт үндэслэсэн байх хэрэгтэй. Энэ нь биологи төрөл зүйлийг хамгаалах талаархи шийдвэр гаргах одоогийн механизмийг илүү ил тод ардчилсан шинж чанартай болгож ингэсэнээрээ шийдвэр гаргалтад иргэний нийгэм, тэр дундаа нүүдэлчин ардын нээлттэй оролцоог бүрэн хүлээн зөвшөөрч, өөрөө өөртөө туслах болон хамтын менежментийг байгуулах асуудлыг бүрэн дэмжсэн тохиолдолд л боломжтой. Энэ тохиолдолд холбогдох талууд

- 5.1 харилцан зөвшилцөх хэлбэрээр шийдвэр гаргахад чиглэсэн үндэстэн хоорондын хэлэлцээрийг өргөжүүлэх үйл явц, арга замыг бий болгох
- 5.2 соёл ёс заншилд тохирсон зөрчилдөөнийг шийдвэрлэх менежментийн механизм, байгууллагуудыг нэгтгэх
- 5.3 дасан зохицох менежментийг бий болгоход нөхөрлөл, холбоог байгуулахад шаардагдах цаг хугацааг мэдрэх
- 5.4 байгаль хамгаалах асуудалд орон нутгийнханы шийдвэрийг дэмжих
- 5.5 байгаль хамгаалах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхдээ олон урьгалч хандлагыг өөгшүүлэх
- 5.6 Харилцан тустай хамтран ажиллах нөхөрлөл холбоог бий болгоход талуудыг бэхжүүлэх шаардлагатай юм.

Энэхүү тунхаглал нь үзэл бодлын хуваагдлыг багасгахад оруулж буй бидний хувь нэмэр юм. Энд гарч буй санаануудыг цаашид нүүдэлчин ардтай өөрсөдтэй нь өөр бусад хүмүүстэй харилцан санал солилцсоны үндсэн дээр шалгаж, сайжруулан, боловсруулах хэрэгтэй. Гэхдээ эдгээр асуудлуудыг үндэсний болон олон улсын төвшинд ялангуяа удахгүй болох Тогтвортой Хөгжил Дэлхийн Дээд Хэмжээний Чуулга Уулзалт, Дэлхийн Паркуудын Их Хурлаар яаралтай авч үзэх нь чухал юм.

## ТУНХАГЛАЛ ГАРГАСАН ТАЛУУД

Алежандро Аргумедо	Перу улсын Нутгийн Уугуул Иргэдийн Биологи Төрөл Зүйлийн Сүлжээ, Quechua-Aymara ANDES Холбоо
Ричард Бакер	Австралийн Үндэсний Их Сургуулийн дэргэдэх Байгаль орчин, Нийгэм, Нөөц баялагийн чиглэлээр мэргэжил олгох сургууль
Ахмед Белал	Египтийн Соуф Вaleyн Их сургууль, UNESCO ECOTECHNE
Гразиа Боррини-Феиерабенд	Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо, Байгаль Орчин, Нийгэм эдийн засгийн бодлогын комисс
Гералдайн Чателард	Италийн Флоренс дахь Европын Их Сургуулийн Хүрээлэн
Даун Чатти	Нэгдсэн Вант Улсын Оксфордын Их Сургуулийн Дүрвэгсэдийг Судлах Төв
Маркус Колчестер	Нэгдсэн Вант Улсын “Ойд Амьдрагсадын Хөтөлбөр”
Кристо Фабрикюс	Өмнөд Афикийн Родесийн Их Сургууль, Байгаль Орчны Шинжлэх Ухааны Хөтөлбөр

Тагхи Фарфар	Ираны ЖЕНЕСТА, Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо, Байгаль Орчин, Нийгэм эдийн засгийн бодлогын комисс
Патрисиа Фийнэй	Нэгдсэн Вант Улс, Хөгжих Эрх, Үүрэг
Грайм Грифин	Австралийн КоммонуэлфийнШУ, Аж Үйлдвэрийн Судалгааны Байгууллага, говь цөлийн бүсийг судлах төв
Маргарет Жакобсон	Намибийн Хөдөөгийн Нэгдсэн Хөгжил, Байгаль Хамгаалал
Крис Жоннсон	Иорданы Байгаль Хамгаалах Нийгэмлэг
Илсу Көүлэр-Ролефсон	Энэтхэгийн Малчдын Холбоо
Терренсе МкКаб	АНУ-ын Колорадогийн Их сургуулийн Хүн Судлалын Тэнхим
Жеф МкНийли	Дэлхийн Байгаль Хамгаалах Нэгдэл
Хелен Ниюнг	Нэгдсэн Вант Улсын Кантербур дэхь Кентийн Их Сургуулийн Байгаль Хамгаалал, Экологийн Хүрээлэн
Гонзало Овиедо	Хүмүүс ба Байгаль Хамгаалалын ОУ-ын зөвлөх
Гарф Овен-Смиф	Намибийн Хөдөөгийн Нэгдсэн Хөгжил, Байгаль Хамгаалал
Адриан Филипс	Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудын Комиссын дарга агсан
Мохаммед Кавабай	Иорданы Байгаль Хамгаалах Нийгэмлэг
Флавиен Ребара	Мадагскарын Дэлхийн Байгаль Хамгаалах Сан
Алан Роуе	Нэгдсэн Вант Улсын Гласгоуын Их Сургуулийн Газар Зүйн Тэнхим
Сабине Шмидт	Монголын Байгаль Хамгаалал ба Орчны Нутгийн Хөгжил Төсөл, GTZ
Ирина Спрингуэл	Египтийн Соуф Валеин Их сургууль, UNESCO ECOTECHNE
Ник Турвэй	Нэгдсэн Вант Улсын Баримтат Кино найруулагч
Рийд Уадлей	АНУ-ын Колумб дахь Миссурийн Их Сургуулийн Хүн Судлалын Тэнхим